



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 02 сарын 06 өдөр

Дугаар А/МТ

Есөнбулаг сум

Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.30 дахь хэсэг, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.5 дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.4,14.7 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тайшир сумын нутагт ХА-82000149 тусгай зөвшөөрлийн дугаартай "Цахиур" нэртэй талбайд Ашигт малтмал газрын тосны газраас 10/5785 дугаар албан бичгээр хайгуулын тусгай зөвшөөрөл олгох боломжтой гэсэн дүгнэлт ирүүлсэн тул "Балобан юү эй эс технологи" ХХК-д түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгосугай.

2.Хайгуул хийх газар нутаг, талбайн нэр, талбайн хэмжээ, солбицол, хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацааг гэрчилгээгээр баталсугай.

3.Хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа явуулж, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг тусгай зөвшөөрөл эзэмшигч "Балобан юү эй эс технологи" ХХК (Г.Амармэнд)-д үүрэг болгосугай.

4 Хайгуулын тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг тусгай зөвшөөрлийн болон зураг зүйн бүртгэлд бүртгэж, хуулийн дагуу хяналт тавьж ажиллахыг Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэс (Д.Чинзориг), Байгаль орчны газар (Д.Батмагнай), Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Ж.Мянганбаяр), Тайшир сум (Н. Сумъяабазар) нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г ЧИНБАТ



پسندیده میسر

ژنوب - سپهر سنجیدار در سراسر (مختص) در سراسر

Handwritten signature

Handwritten text: ۱۳۸۵/۰۶/۲۵

کتابخانه ملی

مکتوبه سنجیدار در سراسر (مختص) در سراسر

پسندیده میسر در سراسر (مختص) در سراسر . . . ۱۳۸۵/۰۶/۲۵

۱ . . . ۱۳۸۵/۰۶/۲۵

۲ . . . ۱۳۸۵/۰۶/۲۵

۳ . . . ۱۳۸۵/۰۶/۲۵



ژنوب ، کتوبه

8000010175